



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шилүүстэй сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/150/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улиастай хот
2025 он

Төрийн аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-undraaD@audit.gov.mn

Ахлах аудитор: Х.Болдбаатар
Утас: 99105506
Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn

Аудитор: Г.Баасанжаргал
Утас: 99032514
Цахим хаяг: BaasanjargalG@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	15
3.5.3 Нэмэлт төсөв.....	15
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	16
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар.....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт.....	19
5.2 Албан шаардлага.....	19
5.3 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ШИЛҮҮСТЭЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.ГАНБОЛД-д

2025.02.10 № 48
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шилүүстэй сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Шилүүстэй сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс өмнөх онд 10.0 сая төгрөгөөр сумын сүлд дууны клип хийхээр гаргасан ч тус ажил зохион байгуулагдаагүй, мөн сангийн хөрөнгөөс сумын 100 жилийн ойтой холбоотой үнэмлэх, тэмдэг, чихэр, гарын бэлэг зэрэгт 40.0 сая төгрөгийн зориулалт бус, үр ашиггүй зардал гаргасан, малчдын зөвлөгөөн зохион байгуулж 12.5 сая төгрөгийн хоол, хүнсний материал гаргасан бөгөөд анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, багийн Засаг дарга нар болон малчдыг туршлага судлуулах ажлын хүрээнд шатахуун зарцуулсны замын хуудасгүй, ажлын тайлангүй, олон жилийн насжилттай 1.8 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй зэрэг зөрчлүүд гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1, 6.4.2, 6.4.8, 16.5.5 дахь заалт болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.4 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, 20.1.7 дахь заалт, УСНББОУС-2 зэрэг заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь санхүүгийн тайланд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэргүй 1,359.3 сая төгрөгийн барилга, байгууламжийг данс бүртгэлд тусгасан, 5.4 сая төгрөгийн зардлыг зөв ангилж бүртгээгүй, байгууллагад төлөх 98.9 сая төгрөгийн өглөгийг тусгаагүй, үнэ төлбөргүй хүлээн авсан 40.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 15.0 сая төгрөгийн бараа материал зэргийг данс бүртгэлд тусгаагүй алдаа, зөрчил гаргаж аудитын явцад залруулсан байна.

Аудитын гол асуудал

Шилүүстэй сумын Засаг даргын Тамгын газар нь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил болон сумын 100 жилийн ойтой холбоотой нийт 510.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 32.5 сая төгрөгийн бараа материалыг тус тус данс бүртгэлд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 98.9 сая төгрөгөөр Шилүүстэй сумын төрийн байгууллагуудын компьютер, тоног төхөөрөмжийг шинэчлэсэн байна. Мөн нийтийн биеийн тамирын талбай байгуулах ажлын 368.8 сая төгрөгийн гэрээ хийгдсэн бөгөөд 70 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Д.БАТ-УНДРАА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мян.төг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	78,274.94	132,813.36
33	АВЛАГА	1,787.50	1,787.50
335	Бусад авлага	1,787.50	1,787.50
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,787.50	1,787.50
35	БАРАА МАТЕРИАЛ	76,487.44	131,025.86
354	Хангамжийн материал	76,487.44	131,025.86
35410	Бичиг хэргийн материал	780.22	774.82
35420	Аж ахуйн материал	18,076.48	9,209.70
35430	Сэлбэг хэрэгсэл	415.10	-
35450	Барилгын засварын материал	707.00	457.00
35470	Бусад хангамжийн материал	56,508.65	120,584.34
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	879,467.82	1,295,722.61
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	879,467.82	1,295,722.61
392	Биет хөрөнгө	871,866.32	1,289,476.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	879,124.18	1,046,626.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	(161,009.28)	(229,141.16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	167,290.15	327,305.28
39204	Хуримтлагдсан элэгдэл	(103,987.17)	(131,889.57)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	221,966.45	375,981.21
39206	Хуримтлагдсан элэгдэл	(160,144.87)	(178,639.72)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,462.87	70,624.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	(36,812.26)	(41,367.86)
39214	Бусад үндсэн хөрөнгө	34,494.00	74,494.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(26,249.70)	(26,249.70)
39217	Ном	1,731.96	1,731.96
393	Биет бус хөрөнгө	7,601.50	6,246.50
39301	Программ хангамж	7,555.00	7,555.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,207.50)	(3,562.50)

39303	Бусад биет бус хөрөнгө	2,254.00	2,254.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>957,742.76</u>	<u>1,428,535.97</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>380.00</u>	<u>98,908.04</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	380.00	98,908.04
413	Өглөг	380.00	98,908.04
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	380.00	-
4136	Бусад өглөг	-	98,908.04
41361	Байгууллагад төлөх өглөг	-	98,908.04
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>957,362.76</u>	<u>1,329,627.93</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	957,362.76	1,329,627.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	383,252.13	383,252.13
51101	Өмч: - төрийн	383,252.13	383,252.13
512	Хуримтлагдсан үр дүн	197,275.37	569,540.54
51210	Өмнөх үеийн үр дүн	197,275.37	197,275.37
51220	Тайлант үеийн үр дүн	-	372,265.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	376,835.26	376,835.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>957,742.76</u>	<u>1,428,535.97</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	898,269.49	1,711,357.97
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	143,084.31	543,334.71
120	Нийтлэг татварын бус орлого	143,084.31	543,334.71
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	143,084.31	543,334.71
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	143,084.31	543,334.71
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	755,185.18	1,168,023.26
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	751,737.23	1,168,023.26
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	671,776.90	1,168,023.26
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	79,960.33	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,447.95	-

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,447.95	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	706,806.82	1,270,139.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	706,806.82	1,270,139.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	693,177.18	1,065,071.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	339,720.68	499,812.28
210101	Үндсэн цалин	236,868.43	313,723.42
210102	Нэмэгдэл	91,980.71	171,631.16
210104	Урамшуулал	10,871.54	14,457.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,313.27	62,678.02
210201	Тэтгэврийн даатгал	29,979.91	42,988.94
210202	Тэтгэмжийн даатгал	3,397.21	5,057.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,717.77	2,518.86
210204	Ажилгүйдлийн даатгал	656.22	2,422.54
210205	Эрүүл мэндийн даатгал	6,562.17	9,690.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,037.01	36,759.33
210301	Гэрэл, цахилгаан	3,398.77	6,899.14
210302	Түлш, халаалт	13,638.24	29,860.18
2104	Хангамж, бараа материалын зардал	31,647.31	58,806.78
210401	Бичиг хэрэг	1,552.08	1,483.60
210402	Тээвэр, шатахуун	28,139.73	31,059.95
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,910.50	2,298.44
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	45.00	-
210408	Бараа материал акталсны зардал	-	23,964.79
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	325.00	6,906.20
210604	Урсгал засвар	325.00	6,906.20
2107	Томилолт, зочны зардал	6,997.20	6,757.40
210702	Дотоод албан томилолт	6,997.20	6,757.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,592.90	3,494.74
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	900.00	2,785.00
210803	Даатгалын үйлчилгээ	469.10	468.31
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50.57	100.65

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55.00	73.80
210807	Газрын төлбөр	118.22	66.97
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	252,543.81	389,857.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	224,679.07	265,219.58
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	80.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,864.74	124,557.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,629.65	205,067.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	72,015.90
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	33,393.90
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	38,622.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,629.65	133,051.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,629.65	133,051.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>191,462.67</u>	<u>441,218.44</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	68,953.28
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		68,953.28
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(68,953.28)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>191,462.67</u>	<u>372,265.16</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мян.төг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>755,185.18</u>	<u>1,168,023.26</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	755,185.18	1,168,023.26
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	751,737.23	1,168,023.26
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	671,776.90	1,168,023.26
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	79,960.33	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,447.95	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,447.95	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>682,630.18</u>	<u>1,168,023.26</u>

21	УРСГАЛ ЗАРДАЛ	682,630.18	1,168,023.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	669,000.53	962,955.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	342,318.68	500,192.28
210101	Үндсэн цалин	237,351.45	318,503.55
210102	Нэмэгдэл	94,095.69	167,280.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	10,871.54	14,408.41
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,335.27	62,678.02
210201	Тэтгэврийн даатгал	26,699.77	42,988.94
210202	Тэтгэмжийн даатгал	3,408.90	5,057.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,727.10	3,388.79
210204	Ажилгүйдлийн даатгал	681.80	1,219.93
210205	Эрүүл мэндийн даатгал	6,817.70	10,022.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,037.01	36,759.33
210301	Гэрэл, цахилгаан	3,398.77	2,711.38
210302	Түлш, халаалт	13,638.24	34,047.95
2104	Хангамж, бараа материалын зардал	18,349.44	20,859.64
210401	Бичиг хэрэг	1,603.68	1,433.70
210402	Тээвэр, шатахуун	14,835.27	17,083.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,910.50	2,342.94
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,494.60	11,413.20
210604	Урсгал засвар	1,494.60	11,413.20
2107	Томилолт, зочны зардал	6,997.20	6,757.40
210702	Дотоод албан томилолт	6,997.20	6,757.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,729.90	23,694.74
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	900.00	22,004.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	469.10	468.31
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50.57	100.65
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55.00	73.80
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	137.00	981.00

210807	Газрын төлбөр	118.22	66.97
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	240,738.44	300,601.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	240,490.44	300,521.13
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	248.00	80.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,629.65	205,067.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	72,015.90
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	33,393.90
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	38,622.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,629.65	133,051.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,629.65	133,051.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>72,555.00</u>	≡
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	72,555.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	72,555.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	72,555.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	72,555.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(72,555.00)</u>	≡
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мян.төг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	383,252.13	376,835.26	5,812.70	765,900.09
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	383,252.13	376,835.26	5,812.70	765,900.09
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	191,462.67	191,462.67

C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	383,252.13	376,835.26	197,275.37	957,362.76
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	383,252.13	376,835.26	197,275.37	957,362.76
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	383,252.13	376,835.26	197,275.37	957,362.76
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	372,265.16	372,265.16
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	383,252.13	376,835.26	569,540.54	1,329,627.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мян.төг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	773,206.60	813,400.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	773,206.60	813,400.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	701,190.70	741,384.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	518,436.90	500,192.28
210101	Үндсэн цалин	350,340.80	318,503.55
210102	Нэмэгдэл	168,096.10	167,280.32
210104	Урамшуулал	-	14,408.41
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,804.70	62,678.02
210201	Тэтгэврийн даатгал	44,067.20	42,988.94
210202	Тэтгэмжийн даатгал	5,184.40	5,057.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,147.50	3,388.79
210204	Ажилгүйдлийн даатгал	1,036.90	1,219.93
210205	Эрүүл мэндийн даатгал	10,368.70	10,022.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,971.60	36,759.33
210301	Гэрэл, цахилгаан	2,651.10	2,711.38
210302	Түлш, халаалт	54,320.50	34,047.95

2104	Хангамж, бараа материалын зардал	18,079.10	18,079.10
210401	Бичиг хэрэг	1,255.80	1,433.70
210402	Тээвэр, шатахуун	14,181.10	14,302.46
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,642.20	2,342.94
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,494.60	11,413.20
210604	Урсгал засвар	1,494.60	11,413.20
2107	Томилолт, зочны зардал	3,257.40	6,757.40
210702	Дотоод албан томилолт	3,257.40	6,757.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,888.00	2,590.74
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,200.00	900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	560.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	469.10	468.31
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227.70	100.65
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73.80	73.80
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203.40	981.00
210807	Газрын төлбөр	138.30	66.97
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15.70	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,258.40	102,914.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,955.00	102,834.21
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303.40	80.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,015.90	72,015.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,015.90	72,015.90
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,393.90	33,393.90
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	38,622.00	38,622.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,546,413.20	1,689,010.60
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	773,206.60	844,505.30
132001	Орон нутгийн төсвөөс	773,206.60	844,505.30

62	АЖИЛЛАГСДЫН ТОО	19	19
620001	Удирдах ажилтан	7	7
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	3	3
620004	Гэрээт ажилтан	-	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	19	19
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5
650010	Гэрээт ажилтан		
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мян.төг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	221,571.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	221,571.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	221,571.46
2104	Хангамж, бараа материалын зардал	2,780.54
210401	Бичиг хэрэг	
210402	Тээвэр, шатахуун	2,780.54
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,104.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,104.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	197,686.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	197,686.92
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	101,946.50
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	101,946.50
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	323,517.96
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	323,517.96
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	323,517.96

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шилүүстэй сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол улсын Засгийн газар, аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрүүд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний Тэргүүлэгчдийн хуралдаанаас гаргасан шийдвэрийг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах төрийн байгууллага, мэргэжилтэн, албан хаагч багийн Засаг дарга нарын ажлыг уялдуулан оновчтой бодлого, зохицуулалтаар хангаж орон нутгийн хөгжлийн төлөө төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага иргэдэд төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэж, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр иргэддээ үнэнч шударга үйлчлэхэд чиглэгдэнэ.

Тус байгууллага нь “Орон нутгийнхаа хөгжил цэцэглэлтийн төлөө сэтгэл оюунаа зориулан ажиллаж хуулиа дээдлэн төрийн үйлчилгээг иргэдэд чанартай хүртээмжтэй шуурхай хүргэхэд оршино” гэсэн зорилгын хүрээнд 2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт 100 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийг эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн 96 хувиар үнэлэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Шилүүстэй сумын Засаг даргын Тамгын газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн албаны тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Шилэн дансны тухай, Хөдөлмөрийн тухай, Татварын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөхөөс гадна Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам бусад хууль, тогтоомж, журмуудыг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит болон аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шилүүстэй сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шилүүстэй сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 470,793.2 мянган төгрөгөөр буюу 49.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,787.5	1,787.5	-
Бараа материал	76,487.4	131,025.8	54,538.4
Үндсэн хөрөнгө	879,467.8	1,295,722.6	416,254.8
Нийт хөрөнгө	957,742.7	1,428,535.9	470,793.2
Өр төлбөр	380.0	98,908.0	98,528.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	957,362.7	1,329,627.9	372,265.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	957,742.7	1,428,535.9	470,793.2

Дээрх хүснэгтээс харахад авлага, бараа материал, үндсэн хөрөнгө дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Бараа материал данс өмнөх оноос 54,538.4 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар 32,477.0 мянган төгрөгийн аж ахуйн материал болон бусад хангамжийн материалыг орлогод авсан, тайланд онд 147,728.4 мянган төгрөгийн худалдан авалт, 101,702.2 мянган төгрөгийн өмнөх он болон тайлант оны зарцуулалт, 23,964.8 мянган төгрөгийн бараа материалыг холбогдох шийдвэрийн дагуу акталж данснаас хассан зэрэгтэй холбоотой байна.

Харин үндсэн хөрөнгө данс 416,254.8 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн тус сумдын төрийн байгууллагуудын компьютер, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын 98,908.0 мянган төгрөгийн худалдан авалт, хандиваар ирсэн 510,857.7 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод авсан, 73,071.2 мянган төгрөгийн хөрөнгийн акталж, худалдсан болон тайлант оны элэгдлийн зардалд 124,557.7 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо /эздийн өмч/ 372,265.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр, нийт зарлагыг 749,012.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 24,194.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 773,806.6 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 109,062.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглал хөтөлбөрийн үндсэн болон баг хороо, мэдээлэл сурталчилгаа, орон нутгийн нөөц хөрөнгө зэрэг 6 үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхээр 882,869.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 844,505.3 мянган төгрөгийн санхүүжилт олгогдож, гүйцэтгэл 813,400.2 мянган төгрөг буюу 96.3 хувьтай бөгөөд үйл ажиллагааны орлого 31,105.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Код	Хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	548,300.1	523,786.3	24,513.8	95.5
2	80106	Баг хорооны үйл ажиллагааны зардал	106,289.3	113,863.7	(7,574.4)	107.1
3	80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	1,200.0	900.0	300.0	0.0
4	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	72,015.9	72,015.9	-	0.0
5	81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	63,700.0	55,199.4	8,500.7	86.7
6	81701	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	53,000.0	47,634.9	5,365.1	89.9
		Дүн	844,505.3	813,400.2	31,105.1	96.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр нийт 323,518.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэх эс үүсвэр бүрдсэн бөгөөд 221,571.5 мянган төгрөгийг бараа үйлчилгээний зардалд зарцуулж, 101,946.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ, төсөл хөтөлбөр гараагүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/

№	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих төсөвт өртөг	Шалгаруулалтын арга
1	Төрийн байгууллагуудын компьютер, тоног төхөөрөмжийг шинэчлэх	100,000.0	100,000,000	Харьцуулалтын арга
2	Шилүүстэй суманд нийтийн биеийн тамирын талбай байгуулах	370,000.0	175,276.3	Нээлттэй тендер шалгаруулалтын арга

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шилүүстэй сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэл, сангийн сайдын тушаал, журамтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баасанжаргал гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ц.Оюунсувд аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шилүүстэй сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 3/14 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр

дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлтийн нийт орлого 441,778.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8,835.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар материаллаг байдлыг сонгосон тул, гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн тайлангийн нийт орлогын 1,711,358.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 34,227.2 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй ч батлагдсан төсвийн хүрээнд зарлага гарган ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 18,244.6 мянган төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 6,157.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 41,844.2 мянган төгрөг, тээвэр шатахууныг 808.6 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор (shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим санд оруулсан байдлыг шалгахад тухайн жилийн төсөвт /зорилтот түвшинд/ орсон нэмэлт, өөрчлөлт 109,062.5 мянган төгрөгийг, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл зэргийг мэдээлээгүй байна. Бусад үзүүлэлтээр мэдээлсэн байдлын хэрэгжилт 99.9%-тай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Шилүүстэй сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийхэд зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 41,004.3 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага өгсөн байна. Хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	4	41,004.3	4	53,993.6	100
Зөвлөмж					
Нийт дүн	4	41,004.3	4	41,004.3	100

Аудитын шийдвэрүүдийг хэрэгжүүлэн ажилласан ч өмнөх онд 10,000.0 мянган төгрөгөөр сумын сүлд дууны клип хийх ажил зохион байгуулагдаагүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,518,622.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,518,622.9 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

Аудитын явцад 5,390.6 мянган төгрөгийн зардлыг зөв ангилж бүртгээгүй, 98,908.0 мянган төгрөгийн байгууллагад төлөх өглөгийг бүртгэлд тусгаагүй, 40,000.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, 15,000.0 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй, төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэргүй 1,359,324.3 мянган төгрөгийн барилга байгууламжийг данс бүртгэлд тусгасан зэрэг алдааг залруулсан байна. Энэ нь УСНББОУС-1, АДБОУС 200, 2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5 дахь заалтууд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 15 дугаар зүйлийн 15.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 59,286.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 40,000. мянган төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага, 19,286.8 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн байна.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй байна.

5.2 Албан шаардлага

Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс өмнөх онд 10.0 сая төгрөг гаргаж сумын сүлд дууны клип хийх ажил зохион байгуулагдаагүй, мөн сумын 100 жилийн ойтой холбоотойгоор тэмдэг, үнэмлэх, чихэр, гарын бэлэг зэргийн 40,000.0 мянган төгрөгийн зориулалт бус зардал гаргасан зөрчилд 1 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Олон жилийн насжилттай 1,787.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй зөрчил илэрсэн нь УСНББОУС-1, АДБОУС 200, 2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5, 7.1.3.8, мөн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дээрх авлагын эзэн холбогдогчийг тодорхой болгон барагдуулах арга хэмжээ авч ажиллах;

2. Зориулалт бус зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс малчдын зөвлөгөөн зохион байгуулж 12,499.3 мянган төгрөгийн хоол хүнсний материал гаргаж, зориулалт бус зардал гаргасан мөн анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй зөрчил илэрсэн нь УСНББОУС-1, АДБОУС 200, 2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5, 7.1.3.11, мөн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-т “төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллах;

3. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Багийн дарга нар болон малчдыг туршлага судлуулах ажлын хүрээнд 5,000.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулалтын замын хуудасгүй, ажлын тайлангүй зэрэг анхан шатны баримт дутуу ажил гүйлгээг данс бүртгэлд тусгасан зөрчил илэрсэн нь УСНББОУС-1, АДБОУС 200, 2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5, мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.7-д “тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй ажил гүйлгээг данс бүртгэлд тусгахгүй байх;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Зардлуудыг зөв ангилж бүртгээгүй	1	5,390.6			1	5,390.6	1	5,390.6				
Хандиваар ирсэн үндсэн хөрөнгө, бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй байх	2	55,000.0	2	55,000.00			2	55,000.0				
Байгууллагад төлөх өглөлийг бүртгэлд тусгаагүй	1	98,908.0	1	98,908.00			1	98,908.0				
Холбогдох байгууллагын шийдвэргүй барилга байгууламжийг данс бүртгэлд тусгасан	1	1,359,324.3			1	1,359,324.3	1	1,359,324.3				
Дүн	5	1,518,622.9	3	153,908.00	2	1,364,714.9	5	1,518,622.9	-	-	-	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шийлжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс өмнөх онд 10.0 сая төгрөг гаргаж сумын сүлд дууны клип хийх ажил зохион байгуулагдаагүй, мөн сумын 100 жилийн ойтой холбоотойгоор тэмдэг, үнэмлэх, чихэр, гарын бэлэг зэргийн 40,000.0 мянган төгрөгийн зориулалт бус зардал гаргасан	1	-			0	-			1	1		
Олон жилийн насжилттай 1,787.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй	1	1,787.5			0	-	1	1787.5				
Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс малчдын зөвлөгөөн зохион байгуулж 12,499.3 мянган төгрөгийн хоол хүнсний материал гаргаж, зориулалт бус зардал гаргасан мөн анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй	1	12,499.3			0	-	1	12499.3				
Багийн дарга нар болон малчдыг туршлага судлуулах ажлын хүрээнд 5,000.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулалтын замын хуудасгүй, ажлын тайлангүй зэрэг анхан шатны баримт дугуу ажил гүйлгээг данс бүртгэлд тусгасан	1	5,000.0			0	-	1	5000				
Дүн	4	19,286.8	0	-	0	-	3	19,286.8	1	1	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

2025.02.25

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР

2025.02.25

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Г.БААСАНЖАРГАЛ

2025.02.25